



СЭЛЭНГЭ АЙМАГ  
САНТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 01 сарын 31 өдөр

Дугаар А/06.

Цагаантолгой

Хязгаарлалтын дэглэмийг цуцлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.12, 66 дугаар зүйлийн 66.1, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 18-р зүйлийн 18.3 дахь заалт, Засгийн газрын 2018 оны 266 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан “Хорио цээр, хязгаарлалтын дэглэмийн үед хэрэгжүүлэх үйл ажиллагааны журам”, сумын Мал эмнэлгийн тасгийн 2022 оны 01 сарын 21-ний өдрийн саналыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын нутаг дэвсгэрт бүртгэгдсэн мал, амьтны гоц халдварт шүлхий өвчинтэй тэмцэх зорилгоор 2022 оны 01 дүгээр сарын 07-ны өдрийн А/02 тоот захирамжаар тогтоосон “Хязгаарлалтын дэглэм”-ийг 2022 оны 01 дүгээр сарын 22-ны өдөр цуцалж, мөн өдрөөс эхлэн хэвийн горимд шилжүүлсүгэй.

2. Уг өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг холбогдох хууль, тогтоол шийдвэрийн дагуу шуурхай зохион байгуулж, өвчний талаарх сэрэмжлүүлгийг иргэдэд тогтмол хүргэж, халдварыг дахин тархахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ зохион байгуулахыг үүрэг болгосугай.

3. Захирамжийг хэрэгжүүлэхэд мэргэжлийн нэгдсэн удирдлага, арга зүйгээр хангаж ажиллахыг Мал эмнэлгийн тасгийн тархвар зүйч (Г.Анхбаяр)-д үүрэг болгосугай.

4. Уг захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг сумын Засаг даргын орлогч (Б.Мөнх-Эрдэнэ)-д даалгасугай.



С. ШИЖИРБААТАР

Боловсруулсан: *Т. Амгаль*  
Хянасан: *С. Шелербаев*  
Хувь: *2.*  
Огноо: *2022.01.31* -